



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 15-р хороо, Гандигийн гудамж, NM tower оффис, 8 давхар хурлын танхимд 15:00-16:50 цаг хүртэл <https://agm.mn/> цахим хурлын системээр зохион байгуулагдав.

Хурлын дарга:

Адилбишийн Баттамир

Хурлын ирц:

Инновэйшн Инвестмент ХК-ийн саналын эрхтэй нийт 171,397,098 ширхэг хувьцаанаас 69.12 хувь буюу 127,799,494 ширхэг хувьцаа эзэмшиж буй 31 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хэлэлцэх асуудал:

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	Тогтоол №1				

Хэлэлцсэн нь:

Тооллогын комиссын дарга Б.Онон: Хурлын ирцийг бүртгэж хурлын ирц хүчин төгөлдөр болохыг танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир: Нийт хувьцаа эзэмшигчидэд мэндийг дамжуулж хурлын ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлэв. ХЭЭХ-ын хэлэлцэх асуудал болон дэгийг танилцуулав.

2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг хувьцаа эзэмшигч нарт хүргэв. Үүнд:

1. ТУЗ-ийн бүрэлдэхүүн ердийн 6, хараат бус 3 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулсан.
2. ТУЗ нийтдээ 4 хороонд хуваагдаж 76 тогтоол шийдвэр гаргаж ажилласан.

Гүйцэтгэх захирал Б.Энхболд: Хурлаар хэлэлцэх асуудлыг дэлгэрэнгүй танилцуулав.

Мүүрх аудит ХХК: 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир: Хурлаар хэлэлцэх асуудлын тогтоолын төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Онон: Хувьцаа эзэмшигчдээс асуултуудыг хүлээн авав.

Гүйцэтгэх захирал Б.Энхболд: Тухай бүр хариулав.

Тооллогын комиссын дарга Б.Онон: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалт болон санал тоолох ажил.Санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын батлагдсан тогтоолыг уншиж танилцуулан хэвлэмэл тогтоол дээр гарын үсэг зурж хурлыг хаав.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн **99.98** хувь буюу **125,275,650** ширхэг хувьцаа эзэмшиж буй **21** хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **99.98** хувь зөвшөөрсөн, **0.01** хувь татгалзсан, **0** хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
125,256,220	99.98%	19,430	0.01%	0	0%

Хурлын дарга:



А.БАТТАМИР

Тэмдэглэл хөтөлсөн:

<